



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2022 оны 11 дугаар сарын 08

№ 04/23

Улаанбаатар хот

ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ ТАНАА

Нийслэлийн [redacted] дүүргийн иргэн [redacted] "2022 оны 09 дүгээр сарын 27-ний өдөр Твиттер нийгмийн сүлжээнд илэрхийлсэн үзэл бодолтой нь холбогдуулан Худалдаа хөгжлийн банкнаас нийтэлсэн бичвэр, зургийг устгахыг шаардаж, гар утасны дугаараар холбогдсон нь миний талаарх мэдээллийг зөвшөөрөлгүй цуглуулж, Хүний хувийн мэдээллийн тухай хуулийг зөрчсөн" гэх гомдол гаргажээ.

Гомдлын дагуу шалгах ажиллагаа явуулахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

1. 2022 оны 09 дүгээр сарын 27-ний өдрийн иргэн [redacted] хаягаас Твиттер нийгмийн сүлжээнд шилэн хана бүхий өрөөнд гурван хүн цааш харан зогсож буй зураг, "...өчнөөн хүмүүс дараалалаа хүлээгээд байж бхд энд ингээд жавжигнаад буу халаад сууцгаачих юм! Амралтын өрөө мөрөө гэж байдгүйм байхдаа... [redacted]" гэх бичвэрийг нийтэлсэнтэй нь холбогдуулан Худалдаа хөгжлийн банкны харилцагчийн үйлчилгээний газраас 09 дүгээр сарын 28-ны өдрийн 13:17 цагт 991XXXX2 дугаартай гар утас уруу залгаж, худал мэдээлэл, бусад хүмүүсийн зураг бүхий уг бичвэрийг устгахыг хүссэн байна. Иргэн Н.Хулан хүсэлтийг хүлээн авч, бичвэрийг нэн даруй устгажээ.
2. Иргэн [redacted] овог, нэр, гар утасны дугаар Твиттер нийгмийн сүлжээнд ил байршаагүй байх бөгөөд утасны дугаарыг хэрхэн олж авсан талаар Худалдаа хөгжлийн банкны холбогдох ажилтнууд Комисст зөрүүтэй тайлбар өгсөн байна. Тухайлбал, банкны ахлах мэргэжилтэн И.О "...гүйлгээ авсан баримт дээрээс мэдээллийг харж, банканд дахь бүртгэлтэй дугаараар харилцагчтай холбогдсон...", Харилцагчийн үйлчилгээний газрын ажилтан Э.С "...тухайн өдрийн post нийтлэгдсэнээс хойш лог үлддэг. Зураг авсан үйлдлээр нь шүүгээд олсон. Тухайн салбарын үйлдлийг сайн мэдэхгүй байна. Камер шүүсэн байх" гэх тайлбаруудыг өгч, Твиттер нийгмийн сүлжээнд үзэл бодлоо илэрхийлсэн иргэнтэй холбогдох чиглэлийг салбараас эсхүл банкны төвөөс өгсөн эсэх талаар тодорхой мэдээлэл өгөөгүй байна. Гомдол гаргагчийн зураг авсан байршил, банкны ажилтнуудын өгсөн тайлбар, үйл явдалд ач холбогдолтой мэдээллийг олж авах боломжит нөхцөлийг дүгнэж үзэхэд Худалдаа хөгжлийн банкны холбогдох ажилтнууд иргэн Н.Хулангийн хэн болох, холбоо барих мэдээллийг камерын бичлэг, банканд дахь хэрэглэгчийн мэдээллийг шүүж олсон байж болзошгүй байна.
3. Худалдаа, хөгжлийн банк хэрэглэгчийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах журам баталж, мөрдүүлэх тухай Хүний хувийн мэдээлэл хамгаалах

хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй байж болзошгүй нь анхаарал татаж байна. Тус банкны хуулийн зөвлөх О.Г “Энэ хүний мэдээлэл нь банканд хадгалагдаж байгаа бөгөөд бид харилцагчтай ерөнхий гэрээ байгуулдаг. Уг гэрээний дагуу харилцагч мэдээллээ банканд өгч, банк гэрээний дагуу тухайн хүний мэдээллийг өөртөө агуулж байна. Бид гуравдагч этгээдэд хүний хувийн мэдээллийг өгөөгүй тул хэрэглэгчтэй холбоо барьсан үйлдлийг хувийн мэдээллийг ашигласан гэж үзэхгүй” гэх тайлбар өгчээ. Хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд гэрээний нөхцөлд хяналт тавихаар “Бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл”, “Ти ди би онлайн үйлчилгээний гэрээ”, “Харилцагчид үйлчилгээ үзүүлэх ерөнхий гэрээ (байгууллага, иргэн)”, “Харилцагчийн мэдээллийг ашиглах, харилцагчийн мэдээлэлд нэвтрэх тухай журам” “Дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж ашиглах журам” “Харилцагчийн мэдээлэлд хандсан тухай бүртгэл” зэрэг баримт бичгүүдийг 2022 оны 10 дугаар сарын 22-ны өдөрт багтааж ирүүлэх албан хүсэлт хүргүүлсэн боловч өнөөг хүртэл ирүүлээгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно”, “...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлд “Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно” гэж зааж, халдашгүй чөлөөтэй байх, хувийн орон зай, хувийн нууц, хувийн мэдээллээ хамгаалуулах хүний эрхийг баталгаажуулсан.

Хүний хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахад аюулгүй байдал, хүний эрхийг хамгаалах зорилгоор Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг Улсын Их Хурал 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталж, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх хэсэгт “хүний хувийн мэдээлэл гэж хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг”, 4.1.12 дахь хэсэгт “хүний эмзэг мэдээлэл гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг” ойлгоно гэж заасан байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь хэсэгт хуульд заасны дагуу, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг “мэдээлэл хариуцагч” гэж заасан. Иргэн Н.Хулантай холбоотой камерын бичлэгийн тухайд “Худалдаа хөгжлийн банк” ХХК нь мэдээлэл хариуцагч болно. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх хэсэгт “хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх”, 5.1.2 дахь хэсэгт “хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх”, 5.1.4 дэх хэсэгт “мэдээллийг хуульд заасан үндэслэлээр, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу цуглуулах, боловсруулах, ашиглах” зарчмуудыг мөрдөхөөр заасан. 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “хуульд нийцүүлэн мэдээлэл цуглуулах,

боловсруулах, ашиглах журам баталж, мөрдүүлэх", "мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах талаар мэдээллийн эзэн, хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллага, гуравдагч этгээдийн өмнө хариуцлага хүлээх" зэрэг мэдээлэл хариуцагчийн үүргийг тодорхойлсон. Уг хуулийн 24 дүгээр зүйлд хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих тус Комиссын хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодорхойлсон болно.

Цахим орчинд илэрхийлсэн үзэл бодолтой нь холбогдуулан хүний хувийн мэдээллийг олж авч, бичвэр, зургийг устгуулах хүсэлт тавьсан үйлдэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь хэсэг, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд баталгаажуулсан "үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх" эрх чөлөөний талаас анхаарал татаж байна. Бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах гарцаагүй шаардлагаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлаж болох боловч ийм хязгаарлалтыг хуулиар тогтоосон, дээрх эрх ашгийг хамгаалахад тухайн нөхцөл байдалд гарцаагүй шаардлагатай, тодорхой үзэл бодлыг илэрхийлснээс үүдэн гарах эрсдэл ба хязгаарлалтын хэр хэмжээ тэнцвэртэй байх ёстой. Энэ талаар "...банкны үйл ажиллагааны талаар худал мэдээлэл тараасан, бусад хэрэглэгчийн зургийг ашигласан тул хэрэглэгчдийг хамгаалах зорилгоор бичвэр, зургийг устгахыг хүссэн" гэх тайлбарыг тус банкны хуулийн зөвлөх О.Г-ын Комисст өгчээ. Иргэн [redacted] гомдлыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө зөрчсөн эсэх талаас нь Комисс шалгаагүй боловч түүний нийтэлсэн бичвэр, зургаас үүдэн гарах эрсдэл нь тэдгээрийг устгахыг шаардах гарцаагүй нөхцөл үүсгээгүй, хувийн мэдээллийг хуулиар зөвшөөрсөн зорилгоос гадуур цуглуулж, ашиглах нөхцөлийг бүрдүүлээгүй гэж үзэж байна.

Худалдаа хөгжлийн банкны [redacted] салбар иргэн [redacted] хэн болохыг тогтоож, захидал харилцааны мэдээллийг олж авч, цахим орчинд нийтэлсэн үзэл бодлыг хязгаарлах зорилгоор холбогдсон үйлдэл нь Монгол Улсын иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчсөн байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь хэсэгт тус тус заасан Комиссын гишүүний бүрэн эрхийн хүрээнд хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, дахин зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авахыг шаардаж байна. Үүнд:

1. Хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг зөрчиж, үзэл бодлоо илэрхийлсэн иргэнийг хэн болохыг тогтоож, хувийн эмзэг мэдээлэл болох гар утасны дугаарыг олж авч холбогдсон үйлдэлдээ иргэн [redacted] албан ёсоор уучлалт гуйх;
2. Ийм зөрчлийг цаашид гаргахгүй байх үүднээс дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмж ашиглах тухай дотоод журмыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нийцүүлэн боловсруулах буюу шинэчилж хувийг Комисст ирүүлэх;
3. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн талаар чанартай, үр дүнтэй сургалтад мэдээллийг нийт ажилтнууд, ялангуяа хүний хувийн мэдээлэлтэй ажиллах чиг үүрэгтэй ажилтнуудаа хамруулах;

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт "Комиссын гишүүний шаардлага, зөвлөмжийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй" гэж заасан.

Шаардлагын 1 дэх хэсэгт заасан арга хэмжээг нэн даруй, 2 дахь хэсэгт заасан арга хэмжээг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан, 3 дахь хэсэгт заасан арга хэмжээг боломжит богино хугацааны дотор хэрэгжүүлж, энэ талаарх мэдээллийг холбогдох баримтын хамт Монгол Улсын Хүний эрхийн Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор ирүүлнэ үү.

ГИШҮҮН



Г.НАРАНТУЯА